



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 17/564

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, 4.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 32 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Дархан аварга Ш.Батсуурийн 100 жилийн ойн арга хэмжээ, Ахмадын 2022 оны Улсын аварга шалгаруулах волейболын тэмцээн, Чандмань сумын “Мухулай” цэцэрлэгт хүрээлэнгийн нээлтийн арга хэмжээ, “Урианхай Тува түмний соёлын өвийн өдрүүд-2022” арга хэмжээ, “Монгол Улсын 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл”, “Бүрэн Монгол” төсөл арга хэмжээг орон нутагт зохион байгуулахад шаардагдсан 4,069,100 (Дөрвөн сая жаран есөн мянга нэг зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР